



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/260

Булган сум

2027 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналуудыг нэгтгэн боловсруулж, эрэмбэлэх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 291, 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэг, 63 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2027 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналуудыг нэгтгэн боловсруулж, эрэмбэлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: Г.Гантулга (Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Б.Ариунболд (Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Б.Одхүү (Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

М.Батчимэг (Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Б.Очирсүрэн (Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)

Ч.Ариун (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Иргэний танхимын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Г.Жавзмаа (Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

6326010345

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлтийг хууль журмын дагуу сум, агентлагуудаас саналыг авч боловсруулж, эрэмбэлэхийг ажлын хэсэг (Г.Гантулга)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

